



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/47

Даланзадгад

Журам батлах тухай

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт, Эрүүл мэндийн Сайдын 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 187 дугаар тушаалын хавсралтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээ хийхэд баримтлах журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс /Б.Мидэрсүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 12 сарын 21 өдрийн
А/47 дугаар тушаалын нэгдүгээр
Хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ

НЭГ: ЗОРИЛГО.

- 1.1. Цэвэрлэгээний стандарт мөрдөлтийг сайжруулж эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гарахаас урьдчилан сэргийлж үйлчлүүлэгч болон, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд цэвэр тохилог, эрсдэлгүй орчин бүрдүүлэхэд оршино.

ХОЁР: ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

- 2.1. Цэвэрлэгээ үйлчилгээний ажилтан ажил эхлэхээс 30 минутын өмнө ирж бэлтгэл ажлыг хангасан байна. Цэвэрлэгээнд ашиглагдах багаж хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисыг бэлтгэн ажлын хувцсыг бүрэн өмсөж цэвэрлэгээг хийнэ.
- 2.2. Ажлыг эхлэхдээ ажилбартай өрөөнөөс эхлэн хог хаягдлыг цуглуулан зайлуулж, өдөрт 2-оос доошгүй удаа угаах ба дараа нь хонгил болон коридор, шат зэргийг өдөрт 1 удаа угааж ажлын сүүлийн хагаст өдөрт 2-оос доошгүй удаа угаах өрөөг давтан угааж цэвэрлэнэ.
- 2.3. Хана шал бусад тавилга, хэрэгслийн гадаргууг арчиж цэвэрлэхдээ тоос бичил биетэн агаарт цацагдахаас сэргийлж чийгтэй алчуураар арчиж цэвэрлэнэ.
- 2.4. Цэвэрлэгээг хамгийн дээд хэсэгт байрлаж буй зүйлээс эхэлж дээрээс доош нь чиглэлтэй цэвэрлэгээг хийнэ.
- 2.5. Ээлжийн асрагч үйлчлэгч нар ээлжийн хугацаанд хийсэн ажлаа хариуцсан ахлах сувилагч эмчтэй хамт хүлээлцэх ба дутуу буюу цэвэрлэгээгүй бол улиран цэвэрлэж дараагийн ээлжийн асрагчид хүлээлгэн өгнө.
- 2.6. Үйлчлэгч, асрагч нар хариуцсан цэвэрлэгээний объектын /коридор, заалны/ эд аж ахуйн бүрэн бүтэн байдлыг нүдлэн хамгаална.
- 2.7. Асрагч үйлчлэгч бүр өөрийн ажлын байрны тодорхойлолт, гэрээг баримтлан ажиллах ба журам, стандарт, удирдамжийг бүрдүүлэн хавтас нээж үйл ажиллагаанд ашиглаж, хурал, сургалт, хичээлд оролцсон, өдөр бүр хийсэн ажлын тэмдэглэлийг хөтлөн хариуцсан ахлах сувилагч, бага эмч ажилтанд шалгуулж ажиллана.
- 2.8. Асрагч үйлчлэгч бүр тусдаа цэвэрлэгээний бүрэн багаж хэрэгсэлтэй байх ба цэвэрлэгээний материал хэрэгсэл бүр таних тэмдэгтэй тасаг нэгж өрөө кабинетад дамжуулан хэрэглэхийг хориглоно.

- 2.9. Цэвэрлэгээний материалыг сар бүр татан авч зориулалтын дагуу хэрэглэж зарцуулалтын тайланг хариуцсан ажилтанд тайлагнана.

ГУРАВ: ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ҮЕД МӨРДӨХ ХАЛДВАРИЙН ХЯНАЛТЫН ДЭГЛЭМ

- 3.1. Талбайг цэвэрлэхдээ тогтмол ахуйн бээлий өмсөж хурц үзүүр ирмэгтэй, цахилгааны залгуур разетка, шилэн тавиур тоног төхөөрөмж бүхий зүйлд гэмтэхээс болгоомжлон анхааралтай ажиллана. Хэрэв биедээ гэмтэл шарх авбал цэвэр боолт хийлгэж халдвар судлаач эмчид яаралтай мэдээлэн өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг авна.
- 3.2. Өрөө бүр цэвэрлэгээний хэрэгсэл /шалны мод, хувин, алчуур/ тусдаа, тоосны /Т/, шалны /Ш/, угаалтуурын /У/, ариун цэврийн өрөөний /ОО/ гэх мэт тэмдэгтэй алчууртай байх бөгөөд өрөө хонгил, заалны хана шал бусад хэсгийн цэвэрлэгээг тэмдэг бүхий зориулалтын өнгийн алчуураар хийнэ.
- 3.3. Цэвэрлэгээг дээрээс нь доош чиглэлээр вандан, ширээ, ор, тэргэнцэр, цонхны тавиур шалан дээрх хуримтлагдсан тоос шороог чийгтэй даавуугаар арчиж цэвэрлэнэ. Тоостой гадаргууг хуурайгаар арчих буюу шүүрдэж болохгүй.
- 3.4. Хир болон бохирдлыг бүрэн арилгахын тулд цэвэрлэгээний явцад сойз хэрэглэнэ.
- 3.5. 0,015-0,2% жавелионы уусмалыг цэвэрлэгээ халдваргүйтгэлд хэрэглэх ба 0,015%-ийн уусмалаар шал, хана, хаалга, цонх гэх мэт хатуу гадаргууг, 0,03%-ийн жавелионы уусмалаар ариун цэврийн өрөөний хана шал, суултуур, өвчтөний цагаан хэрэгсэл, 0,06%-ийн жавелионы уусмалаар халдварын эрсдэл өндөртэй ариун цэврийн өрөөний хана шал, суултуур, цэвэрлэгээний материал, өвчтөний цагаан хэрэглэл, 0,1-0,2%-ийн жавелионы уусмалаар гэдэсний халдвартай өвчтөний өрөө палат ариун цэврийн өрөө бусад эд зүйлийг халдваргүйтгэнэ.
- 3.6. Хагалгааны болон ажилбарын өрөөнүүд, багаж хэрэгслүүд, тавилга хэрэгсэл болон бусад бохирлогдсон гадаргууг халдваргүйтгэлийн уусмалаар шүршиж цэвэр зориулалтын алчуураар арчиж халдваргүйтгэнэ.
- 3.7. Асгарсан, цацагдсан цус, биологийн шингэнийг цэвэрлэж халдваргүйтгэхдээ хувийн хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсөж нэг удаагийн алчуур буюу самбай тавьж халдваргүйтгэх бодис цацах буюу шүршиж халдваргүйтгээд бохир нэг удаагийн буюу самбайг халдвартай хог хаягдлын уутанд хийж халдваргүйжүүлэгч, угаалгын нунтаг бүхий алчуураар арчаад гараа угаана.
- 3.8. Тухайн өрөөг цэвэрлэх явцад цэвэрлэгээний уусмал бохирдсон бол заавал сольж дахин цэвэр уусмалаар угаана.
- 3.9. Бохирлогдсон цэвэрлэгээний багаж хэрэгслийг /шалны мод, сав, даавууг/ халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйтгэх, угаалгын бодистой усаар цэвэрлэх, цэвэр усанд зайлах, хатаах дамжлагаар цэвэрлэгээнд бэлдэнэ.

3.10. Үйлдлийн дараа гараас бээлийг тайлж гар угаах стандартын дагуу угааж, гар халдваргүйтгэх спиртэн суурьтай уусмалаар, эсвэл нян утгах савангаар гар угаах дарааллыг баримтлан угаана.

3.11. Цэвэрлэгээ хийх журмыг зөрчсөн буюу ажлын алдаа гаргасан, үүний улмаас үйлчлүүлэгч, эмч эмнэлгийн ажилчдын үйл ажиллагаанд эрсдэл үүссэн бол чанарын баг, албаны хурлаар хэлэлцэн зохих хариуцлагыг тооцно.

ДӨРӨВ: ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭГ ХИЙХ АЖЛЫН ДАРААЛАЛ, АРГАЧЛАЛ

Цэвэрлэх хэсэг	Хуваарь	Хэн гүйцэтгэх	Хяналт
Хана цэвэрлэх	1. Хэрэв хана бохирлогдсон бол 7 хоног тутам их цэвэрлэгээ хийж 0,015%-н жавелионы уусмалаар зориулалтын алчуураар арчиж цэвэрлэнэ	Асрагч үйлчлэгч, их цэвэрлэгээ хийж буй эмч ажилчид	Тасгийн эрхлэгч, халдвар судлаач, чанарын менежер
Тааз цэвэрлэх	14 хоног тутам их цэвэрлэгээ хийх бүрд тасалгааны тоосыг чигтэй даавуугаар унагаж цэвэрлэнэ		Тасгийн эрхлэгч, халдвар судлаач, чанарын менежер
Сандал, цонхоны тавцан	I. Өдөр бүр угаалгын нунтаг бүхий 0,015%-ийн жавелионы уусмалаар, зориулалтын нэвт норгосон алчуураар арчина II. Их цэвэрлэгээний үед цэвэрлэгээний халдваргүйтгэх бодис бүхий уусмалаар хөөсөртөл савандаж угаана		
Шал цэвэрлэх	Өдөр бүр 2-3 удаа шаардлагатай бол өдөрт 3-4 удаа /хэт их бохирлогдсон/ үед халдваргүйжүүлэх уусмалаар угаана	Асрагч үйлчлэгч	Тасгийн эрхлэгч, халдвар судлаач, чанарын менежер
Угаалтуур жорлон цэвэрлэх	Өдөр бүр 2-3 удаа бохирлогдсон тухай бүрд зориулалтын тэмдэг бүхий алчуур хувинг ашиглан 0,03%-ийн жавелионы уусмалаар халдваргүйтгэн угаана	00-н үйлчлэгч	
Хогийн сав цэвэрлэх	Өдөр бүр зориулалтын алчуураар хог болон органик бохирдлыг суллан авч цэвэрлэгээний халдваргүйжүүлэгч бодисоор халдваргүйтгэн сойздож цэвэрлэнэ.	Асрагч үйлчлэгч	Тасгийн эрхлэгч, халдвар судлаач, чанарын менежер
Хог гаргах	Эмнэлгийн болон эмнэлгийн бус хог хаягдлыг зориулалтын тэмдэгт уут буюу цуглуулсан саванд хийж анхаарал болгоомжтой зөөж тээвэрлэнэ	Асрагч үйлчлэгч	
Гадаргуу дээр хуримтлагдсан тоос болон хогийг цэвэрлэх	Өдөр бүр зориулалтын чийгтэй алчуураар арчиж халдваргүйтгэнэ.	Асрагч үйлчлэгч	

ТАВ: ЭРСДЭЛИЙН ЗЭРГЭЭР ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

Бүс	Тухайн бүсэд хамаарах тасаг нэгж	Цэвэрлэгээ хийх уусмал	Цэвэрлэгээ хийх давтамж
А Халдварын эрсдэл өндөр	Тусгаарлах, мэс засал, төрөх, боолт, тарианы, ариутгал, цусны албаны боксын, лаборатори, сүрьеэ, халдварт, амбулаторийн ажилбарын, угаалгын бохирын хэсэг, сэхээн амьдруулах, эрчимт, төрсний болон мэс заслын дараах, нярай, хог хаягдлын цэг, ариун цэврийн өрөө гэх мэт	Халдваргүйжүүлэх уусмал, Халдваргүйжүүлэгч, угаагч нунтгийн холимог уусмал	Бохирдсон тухай бүр, Өдөрт 3-аас доошгүй удаа
В Халдварын эрсдэл дунд	Гал тогоо, амбулаторийн ажилбарын бус өрөөнүүд, эмийн сан, эмчийн өрөө, физик эмчилгээ, сувилагчийн пост, рентген, хэт авиа оношилгоо, зүрхний бичлэг, угаалгын газрын хатаалга, индүүдлэг, хадгалах өрөө, төрөхийн болон мэс заслын өмнөх, цус цуглуулах өрөө гэх мэт	Халдваргүйжүүлэх уусмал, Халдваргүйжүүлэгч, угаагч нунтгийн холимог уусмал	Бохирдсон тухай бүр, Өдөрт 2-оос доошгүй удаа
С Халдварын эрсдэл бага	Захиргаа, сургалтын өрөө, хонгил, хүлээлгийн өрөө, бүртгэл, өлгүүр гэх мэт	Угаалгын нунтаг бүхий уусмал	Өдөр тутам

ЗУРГАА: ЦЭВЭРЛЭГЧ, ҮЙЛЧЛЭГЧ НАРЫН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖЛЫН НОРМ

№	Талбайн ялгавар	Талбайн хэмжээ м ²	
		Коридор	Үйлчилгээний талбай
1	Модон	300-350 м ²	250-300 м ²
2	Дубан	350-400 м ²	300-350 м ²
3	Чулуун	225-375 м ²	275-325 м ²
4	Хулдаасан	315-365 м ²	260-315 м ²
5	Нийлбэр 75 м ²	15-30 хөтөвч гарын угаалтуур	
6	Алаг чулуун шал хана 150 м ²	1 цэвэрлэгч үйлчлэгч ажиллана	
7	Хивсэнцэр	Цахилгаан хэрэгслээр 250-300 м ²	
Гадна талбайн хар зам зүсмэл талбай м ²			
8	Хар зам зүсмэл талбай м ²	Дулааны улиралд	14000-16000 м ²
		Хүйтний улиралд	12000-13000 м ²
9	Явган зам м ²	Дулааны улиралд	14000-16000 м ²
		Хүйтний улиралд	12000-13000 м ²

ДОЛОО: ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БОДИСЫГ НАЙРУУЛАХ

Жавелионыг хуурай нарны гэрэл, чийгээс хамгаалж таглаатай саванд хадгална

Уусмалын хувь	10л усанд /ширхэг /	Халдваргүйжүүлэх зүйл	Хэрэглэх арга
0.015%	1	Ханга шал, хана хаалга, цонх, өрөөний шил, хатуу эдлэл, гал тогооны хэрэгсэл, агаарт цацах	Цацаж, шүршиж, норгож арчих
0.03%	2	Ариун цэврийн өрөөний хана шал, суултуур, цэвэрлэгээний материал, өвчтөний цагаан хэрэглэл	Цацаж, шүршиж, норгож арчих уусмалд байлгах
0.06%	4	Халдварын эрсдэл өндөртэй ариун цэврийн өрөөний хана шал, суултуур, цэвэрлэгээний материал, өвчтөний цагаан хэрэглэл	Цацаж, шүршиж, норгож арчих уусмалд байлгах
0.1%	7	Гэдэсний халдварт өвчин гарсан үед голомтод эцсийн ариутгал халдваргүйтгэл хийх	Цацаж, шүршиж, норгож арчих уусмалд байлгах
0.2%	14		

Журам боловсруулсан

Халдвар хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Болормаа